



**БАЯНХОНГОР АЙМГИЙН  
ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН ДАРГЫН  
ТУШААЛ**

2026 оны 02 сарын 28 өдөр

Дугаар 2/11

Номгон

Эрүүл мэндийн чиглэлээр мэргэжлийн  
үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөлд  
өөрчлөлт оруулах тухай

Эрүүл мэндийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.2, Зөвшөөрлийн тухай хуулийн 1.5 дугаар зүйлийн 6, 3.2 дугаар зүйлийн 1.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Эрүүл мэндийн чиглэлээр мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгох комиссын 2026 оны 02 дугаар сарын 28-ний өдрийн хоёрдугаар хурлын шийдвэрийн дагуу Мандалбаянбулаг ХХК-ний “Сэтгэц, арьс, мэдрэл”-ийн тусламж үйлчилгээний 18 ортой эмнэлгийн үйл ажиллагааны чиглэлд Уламжлалт анагаах ухааны тусламж үйлчилгээг амбулаториор, ЭХО, Хавдрын өвчний оношилгоо, эмчилгээг нэмэлтээр оруулж хавсралтаар баталсугай.

2. Тусгай зөвшөөрлийн нөхцөл шаардлага, холбогдох хууль, дүрэм, журам, Нэгдсэн эмнэлгийн бүтэц, үйл ажиллагаа MNS5095:2017, Эрүүл мэндийн үйлчилгээнд тавих шаардлага MNS7014:2023 стандартуудыг хангаж ажиллахыг тусгай зөвшөөрөл бүхий Мандалбаянбулаг ХХК-ийн захирал (Д.Алгаа)-д үүрэг болгосугай.

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг комиссын ажлын алба, Эмнэлгийн тусламжийн хэлтсийн мэргэжилтэн (О.Найгалмаа)-д даалгасугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН  
ГҮЙЦЭТГЭГЧ Г.ЛХАГВА-ОЧИР



64201031

Эрүүл мэндийн газрын даргын 2023 оны  
02 дугаар сарын 28-ны өдрийн 111  
дүгээр тушаалын хавсралт



Эрүүл мэндийн чиглэлээр мэргэжлийн үйл ажиллагаа  
эрхлэх тусгай зөвшөөрөлд өөрчлөлт хийх  
байгууллагын мэдээлэл

№	Хуулийн этгээд, байгууллагын нэр	Үйл ажиллагааны чиглэл	Хаяг байршил	Хүчинтэй хугацаа	Тайлбар
1	2	3	4	5	6
1	Мандалбаянбулаг ХХК-ийн Мандал баянбулаг 18 ортой эмнэлэг ЭХ-03/03/233 (Улсын бүртгэлийн регистрийн дугаар: 2134179)	Эмнэлгийн мэргэшсэн тусламж үйлчилгээ (Сэтгэц, арьс, мэдрэл, Хавдар 18 оронд, ЭХО оношилгоо, Уламжлалт ангаах ухааны тусламж үйлчилгээг амбулаториор үзүүлэх)	Баянхонгор сум Рашаант 10 дугаар баг	2030.02.01	Хавдрын өвчний оношилгоо, эмчилгээ, ЭХО оношилгоо, Уламжлалт ангаах ухааны тусламж үйлчилгээг амбулаториор үзүүлэх чиглэлийг нэмэлтээр оруулав.

\_\_\_\_\_оОо\_\_\_\_\_